

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/31/-НА-СТА-ТШЗ  
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

<u>1. Аудитын санал дүгнэлт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u> .....	4-8
<u>3. Аудитын тайлан</u> .....	9
<u>3.1 Ерөнхий зүйл</u> .....	9
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u> .....	9
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u> .....	10
<u>3.4 Материаллаг байдал</u> .....	10
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u> .....	11
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u> .....	12
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u> .....	12
<u>3.8 Аудитын гол асуудал</u> .....	13
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u> .....	13
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u> .....	13
<u>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u> .....	14
<u>4. Аудитын илрүүлэлт</u> .....	14
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u> .....	15

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/83  
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН  
ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГА А.ШАРАВНЯМБУУ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ  
19020294

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,706,591.00</b>	<b>10,469,491.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5,166,931.00</b>	<b>4,066,931.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>4,866,931.00</b>	<b>4,066,931.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	4,866,931.00	4,066,931.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>12,539,660.00</b>	<b>6,402,560.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>12,539,660.00</b>	<b>6,402,560.00</b>
35410	Бичиг хэргийн материал	389,160.00	766,160.00
35420	Аж ахуйн материал	8,399,000.00	3,906,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,395,950.00	1,342,450.00
35450	Барилгын засварын материал	355,550.00	387,450.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,423,950,660.70</b>	<b>3,279,371,507.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,423,950,660.70</b>	<b>3,279,371,507.81</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,049,635,660.70</b>	<b>1,905,056,507.81</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,549,607,251.99	2,678,615,372.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-746,557,704.40	-924,116,273.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	638,814,256.00	638,814,256.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-468,787,815.28	-546,277,729.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,380,719.54	38,110,019.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,930,330.89	-14,174,970.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,164,063.00	22,256,663.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,999,687.77	-16,311,396.69
39209	Зам, гүүрийн байгууламж	56,918,608.00	56,918,608.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-35,700,177.18	-42,461,661.18
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,499,100.00	10,499,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	104,473,812.00	104,473,812.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-96,246,434.31	-101,289,291.51
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,374,315,000.00</b>	<b>1,374,315,000.00</b>
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,374,315,000.00	1,374,315,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,441,657,251.70</b>	<b>3,289,840,998.81</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,441,657,251.70</b>	<b>3,289,840,998.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,441,657,251.70</b>	<b>3,289,840,998.81</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		2,378,790,604.74	2,378,790,604.74
51101	Өмч: - төрийн	2,378,790,604.74	2,378,790,604.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>406,201,087.46</b>	<b>257,259,879.04</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	406,201,087.46	409,076,131.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-151,816,252.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	656,665,559.50	653,790,515.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,441,657,251.70</b>	<b>3,289,840,998.81</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,033,396,339.01</b>	<b>724,570,432.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>447,623,439.01</b>	<b>138,797,532.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	447,623,439.01	138,797,532.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	447,623,439.01	138,797,532.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	447,623,439.01	138,797,532.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>585,772,900.00</b>	<b>585,772,900.00</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	585,772,900.00	585,772,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,772,900.00	585,772,900.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>869,331,319.37</b>	<b>876,386,684.89</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>869,331,319.37</b>	<b>876,386,684.89</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>852,420,642.37</b>	<b>856,585,302.03</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>308,115,888.00</b>	<b>326,169,140.76</b>
210101	Үндсэн цалин	308,115,888.00	296,101,730.76
210102	Нэмэгдэл	00.00	24,612,410.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,455,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,675,046.00</b>	<b>47,451,129.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,855,609.00	36,541,830.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,924,188.00	2,491,864.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,339,350.00	4,308,563.36
210204	Ажилгүйдлийн даатгал	505,081.00	373,533.81
210205	Эруул мэндийн даатгал	5,050,818.00	3,735,337.42
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>00.00</b>	<b>14,050,549.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	00.00	4,590,531.00
210302	Түлш, халаалт	00.00	8,640,408.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	819,610.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>91,556,900.00</b>
210401	Бичиг хэрэг	00.00	55,900.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	90,220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,181,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	99,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>15,267,445.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	11,652,000.00
210604	Урсгал засвар	00.00	3,615,445.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>212,059,639.00</b>	<b>12,242,394.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	212,059,639.00	12,242,394.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>296,570,069.37</b>	<b>349,847,743.89</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,628,000.00	64,500,259.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	293,942,069.37	285,347,484.89
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,910,677.00</b>	<b>19,801,382.86</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,876,500.00</b>	<b>00.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,876,500.00	00.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>34,177.00</b>	<b>19,801,382.86</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,177.00	19,801,382.86
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>164,065,019.64</b>	<b>-151,816,252.89</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>164,065,019.64</b>	<b>-151,816,252.89</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2020 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>656,815,963.49</b>	<b>241,985,663.83</b>		<b>3,277,592,232.06</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	150,403.99		150,403.99
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>656,815,963.49</b>	<b>242,136,067.82</b>		<b>3,277,742,636.05</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	-150,403.99	0		-150,403.99
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	164,065,019.64		164,065,019.64
<b>C08</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>656,665,559.50</b>	<b>406,201,087.46</b>	<b>00.00</b>	<b>3,441,657,251.70</b>
<b>D01</b>	<b>2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>656,665,559.50</b>	<b>406,201,087.46</b>	<b>00.00</b>	<b>3,441,657,251.70</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,875,044.47	00.00	2,875,044.47
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>656,665,559.50</b>	<b>409,076,131.93</b>	<b>00.00</b>	<b>3,444,532,296.17</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,875,044.47	00.00	00.00	-2,875,044.47
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-151,816,252.89	00.00	-151,816,252.89
<b>D09</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>653,790,515.03</b>	<b>257,259,879.04</b>	<b>00.00</b>	<b>3,289,840,998.81</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>585,772,900.00</b>	<b>585,772,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>585,772,900.00</b>	<b>585,772,900.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	585,772,900.00	585,772,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,772,900.00	585,772,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>580,220,300.00</b>	<b>585,772,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>580,220,300.00</b>	<b>585,772,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>563,309,623.00</b>	<b>540,031,317.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00.00	328,655,221.05
210101	Үндсэн цалин	00.00	260,635,449.05
210102	Нэмэгдэл	00.00	47,420,717.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	20,599,054.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>00.00</b>	<b>44,665,049.09</b>
210201	Тэтгэврийн даатгал	00.00	27,455,725.18
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,258,648.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	8,561,126.72
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	489,958.89
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,899,589.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>00.00</b>	<b>13,250,549.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	00.00	3,747,521.00
210302	Түлш, халаалт	00.00	8,640,408.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	862,620.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>92,212,000.00</b>
210401	Бичиг хэрэг	00.00	1,008,600.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	90,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,203,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>8,327,498.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	8,327,498.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>30,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	30,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>513,231,714.00</b>	<b>00.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	513,231,714.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,077,909.00</b>	<b>19,982,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,077,909.00	19,982,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,910,677.00</b>	<b>45,741,582.86</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,876,500.00</b>	<b>25,940,200.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,876,500.00	25,940,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>34,177.00</b>	<b>19,801,382.86</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,177.00	19,801,382.86
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,552,600.00</b>	<b>2,938,300.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,552,600.00</b>	<b>2,938,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,552,600.00</b>	<b>2,938,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,552,600.00	2,938,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,552,600.00	2,938,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-5,552,600.00</b>	<b>-2,938,300.00</b>

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /			
		Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,772,900.00	585,738,723.00	585,772,900.00	565,971,517.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,772,900.00	585,738,723.00	585,772,900.00	565,971,517.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	568,896,400.00	568,862,223.00	559,832,700.00	540,031,317.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	341,592,500.00	328,655,221.05
210101	Үндсэн цалин	-	-	278,866,000.00	260,635,449.05
210102	Нэмэгдэл	-	-	36,926,500.00	47,420,717.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	25,800,000.00	20,599,054.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-	49,547,400.00	44,665,049.09
210201	Тэтгэврийн даатгал	-	-	35,553,600.00	27,455,725.18
210202	Тэтгэмжийн даатгал	-	-	3,498,400.00	3,258,648.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	-	2,798,800.00	8,561,126.72
210204	Ажилгүйдлийн даатгал	-	-	699,700.00	489,958.89
210205	Эрүүл мэндийн даатгал	-	-	6,996,900.00	4,899,589.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	15,230,500.00	13,250,549.00
210301	Гэрэл, цахилгаан	-	-	3,540,000.00	3,747,521.00
210302	Тулш, халаалт	-	-	9,030,500.00	8,640,408.00
210303	Цэвэр, бохир ус	-	-	2,160,000.00	862,620.00
210304	Байрны түрээс	-	-	500,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	92,212,000.00	92,212,000.00
210401	Бичиг хэрэг	-	-	1,012,000.00	1,008,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	-	90,000,000.00	90,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	1,200,000.00	1,203,400.00
2105	Нормативт зардал	-	-	8,329,300.00	8,327,498.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	8,329,300.00	8,327,498.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	30,000,000.00	30,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	30,000,000.00	30,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	518,811,900.00	518,784,314.00	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	518,811,900.00	518,784,314.00	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,084,500.00	50,077,909.00	22,921,000.00	22,921,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,084,500.00	50,077,909.00	22,921,000.00	22,921,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,876,500.00	16,876,500.00	25,940,200.00	25,940,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,876,500.00	16,876,500.00	25,940,200.00	25,940,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,876,500.00	16,876,500.00	25,940,200.00	25,940,200.00
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	585,772,900.00	585,738,723.00	585,772,900.00	565,971,517.14
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	585,772,900.00	585,738,723.00	585,772,900.00	565,971,517.14
132001	Орон нутгийн төсвөөс	585,772,900.00	585,738,723.00	585,772,900.00	565,971,517.14
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	39	44	39
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	4	4
620003	Үйлчлэх ажилтан	39	34	39	34

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгөгдсөн зөвлөмж байхгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь Зуунмод хотын хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан иргэдэд ая тухтай цэвэр үзэмжтэй бохирдолгүй, эко орчин бүрдүүлэх тохижилт үйлчилгээний ажил хийж гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний алба юм.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын дотоод хяналтын багийг 2020 оны 4 дүгээр сарын 13-нд ХТГазрын даргын А/06 тоот тушаалаар шинэчлэн байгуулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор хяналт шинжилгээ үнэлгээний журам шинэчлэн боловсруулж, жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг санхүүгийн үйл ажиллагаа болон шилэн дансанд хийсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, Дотоод аудитын албанаас Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд

хяналт шалгалт хийж 9.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн 4 акт тогтоосныг 100% барагдуулж, эрсдэлийг дунд гэж үнэлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,033,396.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,500.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,850.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 10,868.6 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 4,632.0 мянган төгрөгөөр буурсан тул материаллаг түвшинг дахин тооцох шаардлагагүй гэж үзэв.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 1,033,396.3 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 724,570.4 мянган төгрөг, 308,825.9 мянган төгрөгөөр орлого буурсан байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Хот тохижуулах

газарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

**Орлого:**

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 585,772.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 138,797.5 мянган төгрөг, нийт 724,570.4 мянган төгрөг өмнөх оноос 308,825.9 мянган төгрөгөөр буюу 29.89 хувиар буурсан байна.

**Зардал :**

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 876,386.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 586,572.9 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 566,771.5 мянган төгрөг зарцуулсан байна.

**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100142251008 тоот дансанд 2021 онд 585,772.9 мянган төгрөгийн орлого, 585,772.9 төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган.төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	5,166.9	4,066.9	-1,100.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	12,539.7	6,402.6	-6,137.1
Үндсэн хөрөнгө	3,423,950.7	3,279,371.5	-144,579.2
Нийт хөрөнгө	3,441,657.3	3,289,841.0	-151,816.3
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,441,657.3	3,289,841.0	-151,816.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,441,657.3	3,289,841.0	-151,816.3

Авлага дансны үлдэгдэл 4,066.9 мянган төгрөг болж 1,100.0 мянган төгрөгөөр буурсан нь БОНН ХХК-аас авах гэрэл цахилгааны 2017-2018 онуудад үүссэн, 4 жил болсон авлагыг 800.0 мянган төгрөгөөр, хүмүүсээс авах цалингийн урьдчилгааг 300.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,402.6 мянган төгрөг болж 6,137.1 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,289,841.0 төгрөг болж 144,579.2 мянган төгрөгөөр буурсан нь акталж устгасан хөрөнгө болон элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 2,938.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 137,830.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж 9,938.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,289,841.0 мянган төгрөг болж 151,816.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 911,889.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 911,889.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 326,116.2 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 585,772.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний зардал болон хог хаягдал устгах зардлыг бууруулсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 585,772.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 585,772.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 585,772.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 566,771.5 мянган төгрөгийг зарцуулж, 19,801.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 566,771.5 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь 19,801.4 мянган буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар мөнгө зарцуулаагүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2021 онд Эко ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд Зуунмод сумын Засаг даргын санаачилгаар "Манзушир ногоон төгөл"-ийг байгуулсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар тайлант онд 137,830.0 мянган төгрөгийн барилга байгууламж үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Төвлөрсөн хогийн цэгийн талбайн хогийг хийсэхээс болгоомжилж орчныг бохирдуулахаас хамгаалж ландфилийн аргаар булшлан, тэлсэн талбайг 1.5 га-аар багасгаж тавцан үүсгэж тэгшилгээ хийж, хогийн цэгийн орчимд 4-5 удаагийн цэвэрлэгээгээр 500 тн хогийг цэвэрлэж тээвэрлэхэд 912 литр түлш 1,785.3 мянган төгрөг зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар тайлант онд Бодоогийн хөшөө, явган зам засварлахад 684.0 мянган төгрөг, Одонт өндөрлөг засварлахад 129,330.0 мянган төгрөгийн барилга байгууламжийг сайжруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 23, зарлагын 12 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 13 гүйлгээ байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх 1 зөвлөмж, авлагатай холбоотой 1 албан шаардлага өгөгдсөнийг 78.7% хэрэгжүүлэн Хот тохижуулах газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн А/10 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 231,973.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 173,830.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,343.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 56,799.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

##### **4.2.1 Залруулсан алдаа**

Тус байгууллага тайлант оны үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй ирсэн 173,830.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар тайлагнасан нь үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

##### **4.2.2 Төлбөрийн акт**

Тус байгууллага тайлант онд Зуунмод сумын Засаг даргын 2022.11.24-ны өдрийн А/409 тоот захирамжаар Хот тохижуулах газрын даргын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн 1,343.9 мянган төгрөгийн шагналт цалин олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшил, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

##### **4.2.3 Албан шаардлага**

1. Тус байгууллага тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 56,799.6 мянган төгрөгийн 17 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлийг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Хот тохижуулах газар	3	231,973.5	1	173,830.0	1	1,343.9	1	56,799.6	0	0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70272287  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)